



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйлчилгээний 1 дүгээр байрны их засварын ажлын хүрээнд бий болсон 1,498,000,000.00 (нэг тэрбум дөрвөн зуун ерэн найман сая) төгрөгийн хөрөнгийг холбогдох хөрөнгөд капиталжуулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дорноговь аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон нийт 9,144,500.00 (есөн сая нэг зуун дөчин дөрвөн мянга таван зуун) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,

АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны ᠒-дугаар сарын ᠒᠒-ны өдрийн
᠒᠕-дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Хэвлэгч /3 үйлдэлтэй/	ш	1	4,714,500.00	4,714,500.00
2	Мэдрэгчтэй дэлгэц	ш	1	4,430,000.00	4,430,000.00
	Нийт дүн				9,144,500.00 (есөн сая нэг зуун дөчин дөрвөн мянга таван зуун)